

**МОНГОЛ, ОРОСЫН АРД ТҮМНИЙ
ОЮУН САНААНЫ АМЬДРАЛД ТОГТООСОН
ӨНГӨРӨГЧ ЗУУН ЖИЛИЙН ДАРХЛААЖУУЛАЛТ
(1921-2021)**

**IMMUNIZATION IN THE INTELLECTUAL SPHERE OF
MONGOLIAN AND RUSSIAN PEOPLE'S LIFE
DURING THE LAST CENTURY
(1921-2021)**

(1) 3. Мэнд¹, Mend Zorig

(2) 4. Анар², Anar Chuluunbaatar

(3) Б. Эрхэмбаяр³, Erkhembayar Baatarkhuu

Товч агуулга: Монгол-Оросын ард түмний оюун санааны амьдралд хоёр орны найрамдалт харилцаагаар 1921 оноос эхэлсэн нийгмийн хувьсгалт үйл явц тод ул мөрийг үлдээхдээ, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, оршин тогтнохуй, бие даан хөгжих чадварт нөлөөлөх гадаад, дотоодын суурь хүчин зүйл, тэдгээрийн дотор, дэлхий дахины дэг журамд голлох нөлөөтэй тоглогчдын улс төрийн бодит бодлого, чиглэлийг харах өвөрмөц өнцөг бүхий тусгай мэдлэгийг боловсролын хөтөлбөр, хэвлэмэл бүтээл, үзэл суртлын арга хэрэгслээр дамжуулан нийгэм-төрийн байгууллын нэгж, оролцогч нарт түгээж, улс орны өөрийгөө хамгаалах тогтолцоонд дархлаа болгоход ашиглаж байсан түүхийн аяныг сөхөн харж, цаашдын замналд угтан хүлээж болох үйл явцын талаар таамаг, саналыг энэхүү өгүүлэлд дэвшүүлэв.

Түлхүүр үгс: Монгол-Оросын харилцаа; оюун санааны амьдрал дахь дархлаажуулалт; Марксизм; Ленинизм; Сталинизм; ЗХУ-ын идеологи; атеизм; “өнгөрснөөс үлдсэн ул мөр” (“пережитки прошлого”).

Оршил.

Оюун санааны дархлаажуулалт хэмээх ойлголтыг томъёолохуй

“Дэлхий ертөнц ойртож нягтарсан бөгөөд үүнд дэг журмыг тогтоосон байдаг; энэхүү дэг журмыг гагцхүү хүнээс хүн хооронд ярилцаж болохын хувьд, ертөнц анх удаагаа хүнээс хүн хоорондын ертөнц болон хувираад байна” Мартин Бубер

Нутаг залгаа хөрш орнуудын ард түмний оюун санааны харилцааны мөн чанар улс төрийн газрын зураг дээрх хилийн цэгийн уулзвараар тодорхойлогддоггүй, харин хил заагийг үл хамааран сунан орших уул нуруу, урсан

¹ ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн ЭША, магистр.

² Хархорум хүрээлэн ТББ-ын судлаач, магистрант.

³ Судлаач. бакалавр.

дамжих ус гол, саадгүй шилжих цаг уурын адилаар хүнээс хүн хоорондын биологийн болон соёлын солилцоогоор хэлбэр дүрсээ олдог онцлогтой.

Нэрт сэтгэгч Мартин Бубер “хүний мөн чанарын тухай асуулт тавигдах үед, үүнийг аль нэг хувь хүнийг дангаар нь, аль эсхүл олонлог хүмүүсийг хамтаар нь авч үзэх төдийгөөр эхэлж тодорхойлох боломжгүй бөгөөд гагцхүү хүнээс хүн хооронд үүсэх дундын харилцааны бодит байдлаар дамжуулан танин тодорхойлох боломжтой”⁴ хэмээсэн нь улс үндэстний оюун санааны амьдралын мөн чанарыг танин мэдэхэд нэгэн адил хамааралтай. Тэрээр “дэлхий ертөнц ойртож нягтарсан бөгөөд үүнд дэг журмыг тогтоосон байдаг; энэхүү дэг журмыг гагцхүү хүнээс хүн хооронд ярилцаж болохын хувьд, ертөнц анх удаагаа хүнээс хүн хоорондын ертөнц болон хувираад байна”⁵ гэсэн нь ард түмний оюун санааны ертөнц, түүний өөрийгөө хамгаалах дархлаа бол тухайн улс орны оршин тогтохуй, тусгаар тогтнол, аюулгүй байдлын тулгуур багана болдог зүй тогтлыг нээн харуулж өгсөн. Өөрөөр хэлбэл, улс орны аюулгүй байдлыг батлан хамгаалах үндсэн арга нь тухайн үндэстэн, ард түмэн дэлхий дээр зэрэгцэн оршиж буй бусад орнуудын, тэр дундаа голлох нөлөө бүхий улс гүрнүүдийн бодлого, хөтөлбөр, байр суурийг нь танин тодорхойлж, өөрсдийн байр суурийг угтаж буюу хариу тодорхойлох замаар тусгаар тогтнол, үндэсний эрх ашгаа хамгаалах мэдлэг, чадвартай байх явдал юм.

Биологийн эрүүл оршихуйн тогтолцоонд “дархлаа” гэж “аливаа гадны хүчин зүйлсийг ялгаж таних, халдвар тээгч болон гадны бодисоос бие махбодийг хамгаалах цогц систем”⁶-ийг илэрхийлдэг байна. Анагаахын шинжлэх ухааны толь бичигт дурдсанаар, “дархлаажуулалт” гэдэг нь “өвчинтэй тэмцэх бие махбодийн дархлааг идэвхжүүлэн сэргээх үйлчлэлтэй хамгаалагч бодис, вакциныг хийхийг хэлдэг. Дархлааны эрүүл тогтолцоо хөнөөлт түрэмгий бактер, нянг танин илрүүлж, тэдгээрийг устгах буюу аюулгүйжүүлэх эсрэг биетийг ялгаруулж чаддаг. Дархлаажуулалт нь тодорхой өвчлөлөөс өөрийгөө хамгаалахад дархлааны тогтолцоог бэлтгэж өгдөг. Нянгийн гаралтай өвчний эсрэг дархлаажуулалт тогтоохын тулд, вакцины тунд үхжүүлж доройтуулсан нянг хийж ашигладаг. Бактерийн гаралтай өвчин эмгэгийг эсрэг дархлаажуулахын тулд, тухайн бактерийг бүхэлд нь эсэргүүцэх эсрэг биетийг идэвхжүүлэн сэргээх үүднээс бактерийн үхэжсэн хэсгийг өчүүхэн хэмжээгээр нэвтрүүлэн ашиглах боломжтой. Дархлаажуулалтын үр нөлөөг тарилга тунг тодорхой үе шаттайгаар давтан хийх замаар нэмэгдүүлдэг”⁷ аж.

Улс орны аюулгүй байдлыг хангах тогтолцоонд оюун санааны дархлаажуулалт хэмээх ойлголтыг томъёолбол, тухайн орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, хөгжлийн нөөц боломж, ард түмний эх оронч үзэл, итгэл үнэмшил, эв санааны нэгдэлд гадаадын улс орон, бүлгийн ашиг сонирхол, бодлого, үйл ажиллагаа аюул учруулах, хор нөлөө үзүүлэхээс хамгаалах эсрэг биет болж чадах үзэл баримтлал, түүнчлэн нийгмийн зан байдал,

⁴ Martin Buber, “Between Man and Man”, Routledge Classics, 2002, p.8.

⁵ Martin Buber, “Between Man and Man”, Routledge Classics, 2002, p.203.

⁶ “Webster’s New World Medical Dictionary”, Third Edition, New Jersey, 2008, p. 215.

⁷ “Webster’s New World Medical Dictionary”, Third Edition, New Jersey, 2008, p. 215.

олон нийтийн бодол санааг удирдан чиглүүлэх цогц хэрэгсэл, тусгай мэдлэгийг эрх баригч нар бэлтгэх, идэвхжүүлж түгээх, бэлэн байдлыг нь хангах хэлбэрээр илэрхийлэгдэхээр байна. Тухайлбал, 1958 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Батлах хамгаалахын сайд Франц-Жосеф Штраус Баруун Германы ард түмнийг Бүгд Найрамдах Арчилсан Германы үзэл суртлын аяны эсрэг “дархлаажуулах” чиг үүрэгтэй сэтгэл зүйн дайны

алба хэлтсийг үүсгэн байгуулж байсан⁸ бөгөөд энэхүү “дархлаажуулалт”-ын хүрээнд тус сэтгэл зүйн дайны алба хэлтэс нь өөрийн орны дотоод дахь нөхцөл байдлыг мөн адил илүү нягт шинжлэн судлах, мөн Баруун Германы ард түмний эх орноо хамгаалах хүсэл зоригийг бууруулах аюул заналыг авчирч буй “гадаадын болон Герман дахь далд улс төрийн байгууллагууд”-ын үйл ажиллагааг сөрөх үүргийг гүйцэтгэж байжээ⁹. Дархлаажуулалт хэмээх ойлголтыг нөгөө талаас БНАГУ-ын “GDR TV” телевизийн дарга Хайнц Адабек мөн ижил утгаар 1971 онд хэрэглэж, “ангийн тэмцэл үзэл суртлын хүрээнд хурц ширүүн өрнөж буйтай бид нүүр тулах ёстой...олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үндсэн суурь үүрэг бол коммунизмын эсрэг үзлийн хор нөлөөний эсрэг өөрсдийн ард түмнийг дархлаажуулах замаар үзэл суртлын хил заагийг тодорхойлох үйл хэрэгт хувь нэмрээ оруулах явдал мөн”¹⁰ гэж дүгнэн хэлж байжээ.

Германы ард түмэн нэг үндэстэй боловч улс төр, нийгмийн байгууллын ялгаа заагийн улмаас харилцан бие биенийх нь нөлөөллөөс дархлаажуулах хэрэгцээ шаардлага тавигдсан байгаа нь (1) ард түмний өөртөө засан тохиох эрхийн дагуу бүрэлдэн бий болсон эрх баригч төрийн удирдлагын шийдвэрт ард түмний оюун санааны амьдрал гол төлөв захирагдах болдог, мөн (2) оюун санааны дархлаа тогтоох үйл явц нь ихэвчлэн улс төрийн эрх баригч цөөн тооны бүлэг хүмүүсээс ард түмэн, олон нийтийн санаа бодлыг удирдаж, хэлбэржүүлэхэд чиглэсэн нэг урсгалтай ажиллагаа байдаг ба харин цөөн тохиолдолд ард түмний соёл, түүхийн сургамж нь эрх баригчдын оюун санаанд эргэн нөлөөлөх хоёр урсгалыг бий болдог мөн (3) эрх баригч бүлэг өөрсдийн бодлого, үйл ажиллагаанд нийцүүлэн юуг зөвшөөрөн сайшаах, юуг эсэргүүцэн сөрөх шаардлагатай хэмээн үзсэн тэрхүү агуулгыг ард түмний оюун санаанд тусган тогтоохыг шийдвэрлэдэг нийтлэг зүй тогтлыг илтгэнэ.

2. Нэгэн зууны үйлчлэлтэй оюуны дархлаажуулалтад хоёр орны ард түмнийг хамруулсан нь

“Өвөрмөц соёл, эртний бичигтэй байсан монголын ард түмэн колончилогчдын урт удаан ноёрхлын уршгаар дундат зууны үеийн хэмжээнд хадагдаж эрдэм мэдлэг олох бололцоо алдсанаар барахгүй, олон үеийн турш нийтээр бичиг үсэг

⁸ Schlomann, “Der psychologische Krieg der DDR,” p. 252.

⁹ Peter Busch, “West German Psychological Warfare against East German Propaganda in the 1960s”, p.166.

¹⁰ Claudia Dittmar, “GDR Television in Competition with West German Programming”, *Historical Journal of Film, Radio and Television* Vol. 24, No. 3, 2004, p. 332.

Монгол, Оросын ард түмний оюун санааны амьдрал дахь итгэл үнэмшил, бүрэн эрх байдлын үзэл санааны дархлаажуулалт нь түүхэн улбаатай. Энэ оюун санааны дархлаажуулалт аль эрт Монголчуудын санаачилгаар Монголын түүхийн XIII зуун буюу Их Монгол улсын эзэнт гүрэн байгуулагдсан үе дор харь зүгийн олон улс үндэстэнг өөртөө нэгтгэсэн хийгээд байлдан дагуулалтын онцлог нь цуст хядлага болон эвдэн сүйтгэх үйл ажиллагаа бус цэвэр оюун санааны буюу оюун санаа, соёлыг нэгэн зүгт хандуулах тодруулбал "Мөнх тэнгэр"-ийн доор нэг төрийг байгуулж сэргэн мандуулах их зорилгын үүднээс хандсан асар том цар хүрээг хамарсан Монголчуудын үүсгэл санаачилга бүхий үйл ажиллагаа байсан юм.

Энэхүү Монголчуудын оюун санааны их байлдан дагууллыг эхлүүлсэн Эзэн Богд Чингис хааны залгамж халааг авч Мөнх тэнгэрийн хүчин дорх оюун санааны их нэгдлийг үргэлжлүүлэн шинэ шинэ улсуудыг байгуулж өгч тухайн улсаа нэгтгэн зангидаж нэгэн оюун санааны дархлаажилтыг тогтоох зорилготой нүүдэлч соёл болон суурин харь соёлын харилцан зохицол бүхий өвөрмөц төрт улсуудыг байгуулж байсан түүх бий. Энэ талаар Оросын түүхч бичихдээ: Монголчууд Өрнөд Ази болон Зүүн Европт ирж, байлдан дагуулал хийж, шинэ шинэ улсуудыг байгуулсан нь XIII зууны олон улсын харилцаанд шийдвэрлэх үйл явдал болж эдийн засаг болон улс төрийн хүрээнд маш чухал өөрчлөлтүүдийг авчирсан билээ^{11 11 12}.

Орост хийсэн Бат хааны ялалт нь М.Н.Иванин агсны тодорхойлсноор, "зэрлэг эр зориг ба хүний олноор хийсэн зүйл огт биш бөгөөд түүний өвөг эцэг Чингисийн ялалт шиг цэрэг зэвсгийн хосгүй зохион байгуулалт, стратеги тактикийн гарамгай бэлтгэл, эсрэг этгээдийнхээ талаар бодитой судалж байлдааны ажиллгааг сайтар боловсруулсны үр дүн байсан юм"¹³ хэмээн тэмдэглэсэн нь бий. Түүхчид үүнийг "Монгол-Татарын дарангуйлал нь оросын дотоод эв түнжингүй байдалд цэг тавьсан"¹⁴, тусгаар улсын бүрэн эрхт байдлын үзэл санаа дэлгэрэхэд хүргэсэн, энэхүү нөлөөлөл XX зуунд ч ач холбогдлоо алдаагүй гэж мөн дүгнэдэг.

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс болон Монгол Ардын Засгийн газар хооронд 1921 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Москва хотноо байгуулагдсан найрамдлын барилдлагааг байгуулах тухай гэрээ бичиг нь Орос оронд 1917 оны хувьсгал В. И. Ленины оролцоотой өрнөж Хаант Оросын удирдлагыг түлхэн унагаасан, 1918 оны 07 дугаар сарын 10-ны өдөр ЗСБНХОУ-ын Үндсэн хуулийг баталсан, Хаант Оросын талыг баримтлагч Барон Унгерн-Штернберг Монгол нутагт орогнон хүчирхэгжиж эхэлсэн, Зөвлөлт Орос Улс "Хятадын засагтай дипломат харилцаа тогтоохыг хичээн эрмэлзэж байсан"¹⁵

¹¹ "Үнэн" сонин, 1971 -03-01, №52.

¹² Салих Закиров Алтан Ордны улсаас Египеттэй барьж байсан дипломат харилцаа (XIII-XIV зуунд). УБ.,2004. 29-р тал.

¹³ Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ.,87-р тал.

¹⁴ Л.Н.Гончаренко, "Отечественная история", Русь и Орда: Проблемы взаимодействия, стр. 49.

¹⁵ Gerard M. Fritzers, "Outer Mongolia and its International Position", London, 1951, p. 123.

ээдрээтэй нөхцөл байдлын хөврөл дүнд байгуулагдаж шилжилтийн шинэ үеийн тэмдэг болсон. Орос орны нийгмийн шилжилт, бодлого нь В. И. Ленин, И. В. Сталин, Г. М. Маленков, Н. С. Хрущёв, Л. И. Брежнев, Ю. В. Андропов, К. У. Черненко, М. С. Горбачёв, хожим ОХУ-ын удирдагч, тухайн цаг үеийн холбогдох “интернационалч” институтуудын нөлөөгөөр тодорхойлогдож, Монгол орны хувьд үүний нэгэн адилаар Орос орны эрхийг баригч бүлэг, мөн Д. Сүхбаатар, Х. Чойбалсан, Ю. Цэдэнбал, Ж. Батмөнх, одоогийн Монгол Улсын эрх баригчдын болон холбогдох хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойлогдож байсны хувьд 1991 оныг хүртэлх хугацаанд Монгол, Оросын ард түмний оюун санааг хэлбэржүүлэх үйл ажиллагаанд нийтлэг хүчин зүйл нөлөөлж байсан (нэн тэргүүний жишээ гэвэл, БНМАУ-ын Үндсэн хууль 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсаныг ЗСБНХОУ-ын 1918 оны Үндсэн хуультай харьцуулж¹⁶ үзэхэд, оршил хэсэг, хуулийн агуулга бүтэц үндсэндээ адил байсан нь Зөвлөлт Оросын үндсэн хууль БНМАУ-ын үндсэн хуулийн суурь болсон¹⁷, ийм нөлөөллийн зүй тогтол нийгэм, төрийн байгууллын чухал салбаруудад адил хэрэгжсэн болохын нотолгоо болдог) бөгөөд ЗСБНХУ “хүйтэн дайнд ялагдсан” 1991 оноос хойшхи хугацаанд оюун санааг удирдах нийтлэг хүчин зүйл харьцангуй өөрчлөгджээ.

Судлаачдын үздэгээр, “энэ үе зөвхөн феодалын харилцааг эвдэн устгасан үе төдийгүй, бас шинэ эдийн засаг, соёлоо үүсгэн байгуулж, хөдөлмөрчдийн материалын ба соёлын хэмжээг дээшлүүлэх үйлсдээ нам, ард түмний гүйцэтгэсэн өргөн их бүтээн байгуулалтын үе байв. Эдийн засаг, соёлын олон үеийн хоцрогдлыг давж, шинэ монгол улсыг байгуулах тэмцэлдээ олсон бүх амжилт нь МАХН-аар удирдуулсан БНМАУ-ын хөдөлмөрчдийн бүтээлч их хүчин чармайлт, Зөвлөлт Холбоот Улсаас монголын ард түмэнд үзүүлсэн олон талт байнгын тусламжийн үр мөн”^{18 19}. Хоёр орон дахь зуу гаруй жилийн олон улсын харилцаа, геополитик, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралын хөгжил хөдөлгөөн, үйл явцыг 1921-1991 онуудад Оросын эрх баригчдын давамгайлах нөлөөтэй үе, 1992-2021 оны олон ургальч чиг баримжаатай цаг үеэр тоймлон авч үзэхэд, эрх баригч нар тухайн цаг үеийн онцлог хэрэгцээ шаардлагад хөтлөгдөн ард түмний үзэл бодлыг гадаад, дотоодын аюул заналаас хамгаалах боловсролын хөтөлбөр, таниулга, үзэл суртал, ухуулга, шинжлэх ухааны судалгааг цогц байдлаар нэвтрүүлэн ашигласан байна.

Тоймлон харвал, 1921 оны хэлэлцээгээр баталж буй найрамдалт харилцааны мөн чанар, ач холбогдлыг В. И. Ленин “Манай Орос улс танай Монголд энэ хир тусламж үзүүлж байгаагаар үл барам үүнээс хойш мөн элдэв боловсролын явдалд үргэлж тусламж үзүүлнэ”¹⁹ гэж тодорхойлж хэлснийг Б. Цэрэндорж тэмдэглэсэн байх ба “хувьсгалын эхний жилүүдэд л ардын засгаас соёл, шинжлэх ухааныг хөгжүүлэх болон ардын нийтийн боловсролыг

¹⁶ V. Durdenevskii, “The People’s Republics of Central Asia-Mongolia and Tuva”, in S.S., 1929. No. 3(9), 1929, p.108.

¹⁷ Gerard M. Fritzers, “Outer Mongolia and its International Position”, London, 1951, p. 130.

¹⁸ Б.Лхамсүрэн, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь”. УБ., 1975, 124-р тал.

¹⁹ “БНМАУ”-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл”, I боть, УБ., 1964, 31-33 дахь тал.

дээшлүүлэхэд анхаарч байв. Энэхүү зорилгын хүрээнд 1921 оны 11-р сард Судар бичгийн хүрээлэн байгуулагджээ. Намын, төрийн, эдийн засгийн болон соёлын салбарт бэлтгэгдсэн боловсон хүчин дутмаг байгааг нам, засаг сайн мэдэж байлаа. Үүнтэй холбоотойгоор, 1922 онд Дотоод яамны харъяанд ардын боловсролын газрыг байгуулж, улмаар 1924 онд хорин гурван сургууль байгуулсан. Түүнчлэн, яамд жил болгон өөрт шаардлагатай хүний нөөцөө богино хугацааны сургалтаар бэлтгэн авч байлаа. Автономит үед соён гэгээрэлд зориулсан зардал нэг жилд 5000 лан байсан бол 1923 онд ардын боловсролд 87,355 лан, 1924 онд 183,314 лан зарцуулагджээ"²⁰.

"МАХН болон ардын засаг соён гэгээрлийн салбартаа тууштай анхаарч байв. 1934 онд 59 бага, 5 дунд сургуультай байсан бол 1939 онд 93, 12 болж өсөв. 1930 онд суралцагчид 3125 байсан бол 1939 онд 7582 болов. Сонгодог бүтээлүүд, марксизм-ленинизмын, Пушкин, Горький нарын зэрэг бүтээлүүдийг монгол хэлнээ хөрвүүлэн гаргаж байв. Нийслэлд болон орон нутагт 18 дуут кино театраар дамжуулан БНМАУ-ын аж амьдралыг өгүүлсэн богино хэмжээний баримтат кино, Монгол кино үйлдвэрийн дүрс зургийг тогтмол үзүүлдэг байлаа. Улсын театр, цирк, клуб, улаан гэр, явуулын кино машин зэрэг нь ардыг үндэсний хэлбэр маягтай, хувьсгалт агуулгатай шинэ соёлд хүргэсэн."^{21 22 22}.

"БНМАУ-ын төсвийн зардлын бүтэц дараах маягаар өөрчлөгдөв (%)"²².

Төсвийн утга	1934 он	1936 он	1938 он	1940 он
Улс ардын аж ахуй	27,1	15,2	22,3	24,3
Батлан хамгаалах	34,7	49,3	52,5	44,6
Нийгэм соёлын зардал	12,8	14,4	16,0	21,9
Захиргаа, удирдлагын зардал	9,2	8,0	5,0	3,8
Бусад	16,2	13,1	4,2	5,4

"Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжихийн зэрэгцээ БНМАУ, ЗСБНХУ хоёрын соёлын холбоо өргөжин гүнзгийрч ирэв. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хөгжил болсон нилээд хэдэн хэлэлцээр, тухайлбал 1948 оны тавдугаар сарын 12-нд гарын үсэг зурсан ЗСБНХУ-ын дээд сургуулиудад БНМАУ-ын иргэдийг суралцуулах тухай, 1953 оны есдүгээр сарын 11-нд гарын үсэг зурсан радио нэвтрүүлгийн талаар хамтран ажиллах тухай, 1956 оны дөрөвдүгээр сарын 24-нд гарын үсэг зурсан соёлын талаар хамтран ажиллах тухай, 1960 оны арван хоёрдугаар сарын 12-нд гарын үсэг зурсан шинжлэх ухааны талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд хоёр орны соёлын харилцааг зохицуулан хөгжүүлсэн"²³. "1971 оны долоодугаар сарын 20-нд байгуулсан ЗХУ, БНМАУ-ын соёл, шинжлэх ухааны 10 жилийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрт соёл шинжлэх ухааны бүх салбарт хамтын

²⁰ И.Я.Златкин, "Очерки новой и новейшей истории Монголии", 1957, стр.185.

²¹ И.Я.Златкин, "Очерки новой и новейшей истории Монголии", 1957, стр.249

²² И.Я.Златкин, "Очерки новой и новейшей истории Монголии", 1957, стр.250.

²³ Б. Лхамсүрэн, "МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь", УБ, 1975, 107-147-р тал.

ажиллагааны хүрээг өргөжүүлэхээр зааж, 1972 оны гуравдугаар сарын 6-нд Улаанбаатар дахь Зөвлөлтийн шинжлэх ухаан, соёлын ордны эрх, үйл ажиллагааны тухай хэлэлцээр байгуулагдсан²⁴ ба талуудын хоорондын соёл, шинжлэх ухаан, гэгээрэл боловсрол, хэл, оюун санааны харилцан солилцоо тоо, чанарын үзүүлэлтээр эрчимжин хөгжиж, оюун санааны дархжлаажуулалтын суваг, дэд бүтэц бэхэжсэн. Юутай ч, Богд хаант улсын Нийслэл хүрээний сонин бичигт тэмдэглэснээр, тэр үеийн хүн амын бичиг үсэг мэдэх явдал 3-4 хувь байсан²⁵ бол, 1970 он гэхэд нийт хүн амын 82.4 хувь нь бичиг үсэг мэдэх болж, боловсрол бүхий хүний эзлэх хувийн жин 22.1 хувиас²⁶ тогтмол өссөн үзүүлэлттэй байсан нь монголын ард түмний оюун санааны амьдрал дахь маргашгүй дэвшил болж, алс ирээдүйн ямар ч чиг баримжаа бүхий хөгжлийн таатай хөрс суурийг найдвартай тавьсан.

Энэ үед, шашингүйн үзэл, бүх нийтийн боловсрол, хөрөнгөтний байгууллын нийгэм, эдийн засаг, ёс зүйн шинж чанар дахь доройтлыг шүүмжлэх, баялгийн тэгш хуваарилалт, үйлдвэржилтийн арга хэрэгслийг нийтээр өмчлөх, нийтийн сайн сайхан, тусыг эрхэмлэсэн нийгмийг цогцлоон бүтээх гэх зэрэг үзэл санааны агуулга, цогц мэдлэгийг Марксизм, Ленинизм, Сталинизмийн баримжаатайгаар “дархлааньГтун” болгож ашиглаж байсан нь - нэгдүгээрт, тухайн цаг үедээ тус тусын үүргээ Монгол, Оросын ард түмний оюун санааг удирдах, аюулгүй байдлыг хангах ажиллагаанд амжилттай гүйцэтгэсэн; хоёрдугаарт, агуулга тунгийн зарим нь цаг үеийн шалтгаанаар хоцрогдсон, үндэслэл муутай, хэт үзэл суртлын шинжтэй байгаа бол, зарим нь шинжлэх ухааны суурь судалгаатай, одоог хүртэл ач холбогдол, хамааралтай; гуравдугаарт, Монгол, Оросын ард түмний ахуй, сэтгэхүйд тод ул мөрийг үлдээсэн байна. Эрх баригчид ард түмний сэтгэхүйд төрөл бүрийн арга хэрэгслээр тогтоосон дархлаажуулалтын тунгийн ахуй-сэтгэхүйн үйлчлэл, “өнгөрснөөс үлдсэн” ул мөр (“пережитки прошлого/vestiges of the past”) арилаагүй байгаа нь үүнийг 1921-2021 оныг хүртэл хугацаанд нэгэн зуун дамнан хэрэгжсэн дархлаажуулалтын аян гэж дүгнэхэд хүргэнэ.

“Пенин, Сталины удирдлага доорх ЗСБНХУ-ыг дэлхийн анхны үзэл сурталжсан төр улс гэж үзэх нь бий. Зөвлөлтийн үед явагдсан “туршилт”-ын гол бүрдэл шинжүүдийг идеологи, үзэл суртал, ард олныг ухуулах ажил байсан гэж үзвэл, энэ талаар эрдэмтэн судлаачид маш бага анхаарал хандуулж судалсан байдаг нь сонин юм”²⁷. “1930-аад оны дунд үе гэхэд тодрон гарч ирсэн Зөвлөлтийн захиргааны албан ёсны идеологи, үзэл санаа хэлбэр бүрдлээ олоход нь хүргэсэн оюун санааны чиг хандлагыг өгүүлсэн бичмэл бүтээлүүд түгээмэл боловч, Зөвлөлтөд Марксизм-Ленинизмийн хөгжлийг 1930-аад оноос эхлүүлэн ЗСБНХУ задрах хүртэл хугацаагаар бүхэлд нь хамруулан авч үзсэн судалгааны бүтээл

²⁴ “Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1978)”, УБ., 1981, 341-р тал.

²⁵ Б. Ширэндэв, “Монголия на рубеже XIX-XX веков”, УБ., 1963, стр.107.

²⁶ Г. Цэрэндорж, “БНМАУ-д бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгасан нь”, УБ., 1976, 101-р тал.

²⁷ Brandenberger, David, “Propaganda state in crisis : Soviet ideology, indoctrination, and terror under Stalin, 1927-1941”, Yale University Press, 2011, p.1.

нэгээхэн ч байдаггүй”²⁸ хэмээн үзсэн АНУ-ын Калифорния мужийн их сургуулийн профессор Алфред Б. Эванс өөрөө Зөвлөлт дэх Марксизм-Ленинизмийн идеологийн хөгжлийн ерөнхий түүхийг авч үзэх ородлогыг хийхдээ, “(1) Маркс ба Коммунизмын үе шатын онол: Маркс түүхийг тайлбарласан нь, капитализм, хувьсгал, коммунизмыг авч үзсэн нь, (2) Лениний Социалист байгуулалтын үзэл: 1917 оны 10 дугаар сараас өмнө бий болсон онолын хүлээлт төсөөлөл, социализм руу шилжсэн нь, (3) Сталинизмын нэгдсэн хүчирхэгжилт: социализм нэг улс оронд тогтох магад боломжтой гэх үзэл, агуу их өөрчлөлт - нэгдэлжилт болон аж үйлдвэржилт, социализм ба нийгмийн ангиуд, төр улс ба үндэсний үзэл, (4) Сталинизмын бүрэн боловсорсон үе шат: шилжилт доторх залгамж чанар, коммунизмын эхний үе шат, коммунизмд шилжих, диалектикийн хууль ба социализм, (5) Хрущёв: Коммунизмын иж бүрэн байгуулах үзэл, төсөөлөл ба хүсэл эрмэлзэл, коммунизмын материал-техникийн нөөц суурь, урамшуулал, мөнгө, хувийн өмч, Барууны орнуудтай өрсөлдөн оршихуй, (6) Хрущёв: нийгэм, улс төрийн өөрчлөлт, ангийн ялгаваргүй нийгмийн олонлог руу тэмүүлэхүй, улс үндэстнүүдийн харилцаа, шинэ хэвшинжит хүнийг бүтээхүй, нийт ард түмний төр, нам болохуй, коммунизм бүтээхүй, (7) Брежнев: хөгжингүй социализмын үе шат: хөгжингүй хэмээх шинэ ойлголтыг нэвтрүүлсэн нь, социализмын дөрвөн үе шатны онолыг дэвшүүлсэн нь, хөгжингүй социализмын эдийн засаг, эрчимтэй хөгжил ба шинжлэх ухаан-технологийн хувьсгал, үйлдвэрлэлийн харилцаа, (8) Хөгжингүй социализмын нийгмийн бүтэц, нийгмийн хувьсал: хөгжингүй социализмийн үеийн нийгэм, ангийн ижилслийн чиг хандлага, интеграци ба дифференциаци, (9) Социалист амьдралын хэв маяг: үндэстний харилцаа ба Зөвлөлт ард түмэн хэмээх түүхийн шинэ бүлэг хүмүүс, (10) Горбачёв зогсонги байдал, өөрчлөн байгуулалтыг авч үзсэн үе: хөгжингүй социализмын уналт доройтол, хөгжингүй социализмд үл итгэх хандлага, хөгжлийн түргэтгэл, радикал өөрчлөн байгуулалтын үндэслэл, (11) Социалист олон ургальч үзэл: хүнийгсгэл ба догматизм, социализмын зөрчилдөөн, өмч хөрөнгө, зах зээл ба социалист шударга ёс, (12) Мөрөөдөл нуран унасан үе: улс төрийн өөрчлөлт өрнөж, утоп үзлийг таягдан хаясан нь, олон улсын харилцааг шинээр харах болсон нь, Горбачёвизм бүтэлгүйсэн нь, (13) Улс төрийн хариу цохилтын үе: идеологийн дасан зохицол эхэлж, утопи үзэл мөхсөн нь, нийгмийн зөрчлийн талаарх онол хувьсан өөрчлөгдсөн нь, идеологийн түвшин тодорхойлогдож, Марксизм-Ленинизмийн үгүйсгэлийн диалектик хэрэгжсэн цаг хугацаа”²⁹ гэсэн хувилбарыг дэвшүүлсэн байдаг нь Монгол, Оросын ард түмний оюун санааг чиглүүлэгч үзэл санааны хөгжлийн макро түвшин дэх чиг хандлагыг дүрслэн ойлгоход тустай юм.

Судлаач Алфред Б. Эвансын дэвшүүлсэн чухал санаа бол: “Зөвлөлтийн албан ёсны үзэл санаа, итгэл үнэмшлийн тогтолцоон дахь чиг хандлага ямар байсныг судлан авч үзэх нь, хэдийгээр, тэдгээр цогц үзэл санаа нь хуучин Зөвлөлтийн харьяаны бүгд найрамдах улс орнуудын ард түмний дийлэнхи олонхийн нүдэнд үнэ цэнээ алдсан, түүнчлэн тэдгээр цогц үзэл санаа тэргүүлэх үүргийг гүйцэтгэж байсан улс төрийн дэг журам түүх болон хоцорсон эсэхээс үл

²⁸ Evans, Alfred B., “Soviet Marxism-Leninism : the decline of an ideology”, London, 1993, p.1.

²⁹ Evans, Alfred B., “Soviet Marxism-Leninism : the decline of an ideology”, London, 1993.

хамааран, одоог хүртэл ач холбогдолтой байна. Түүхийг танин ойлгохыг хичээн оролдох нь хүсэмжит үйл хэрэг бөгөөд Зөвлөлтийн дэглэмийн удирдагчдын ертөнцийг үзэх үзэл түүхийн үе цаг бүрт ямар байсан болохыг тухайн тогтолцоонд эрх баригч болон гарч ирсэн шинэ тутам “удирдлага захиргаа” бүрийн хэв загварт оруулсан Марксизм-Ленинизмын хувилбарыг бүрэн дүүрэн ухварлан танихгүйгээр ойлгох боломжгүй. Дурдагдаж буй идеологи, эрх барихуйн ээдрээт салаа замууд Зөвлөлт Холбоот Улсын хилийн гадна ч олон талбарт тусч биеллээ олсон бөгөөд ирээдүй цагт өөр шинэ хэлбэр дүрсээр морилон ирж тодрон үзэгдэх магадлалтай. Хуучин Зөвлөлтийн харьяа бүгд найрамдах улс орнуудад буй иргэдийн үнэт зүйлс, итгэл үнэмшил, зан суртахуунд Коммунизмаас хойшхи улс төрийн эрин цаг үед Марксист-Ленинист сэтгэлгээний ул мөрийн болзошгүй нөлөөллийг илрүүлэн шинжлэхэд шаардагдах хангалттай суурь мэдлэгийг найдвартай бий болгохын тулд, ЗСБНХОУ оршин тогтнож байсан сүүлийн хэдэн арван жилийн үед тус холбооны улсад улс төрийн хувьд давамгайлж байсан үзэл санаануудын чиг хандлагын талаар мэдэгдэхүүнтэй байвал зохино. Албан ёсоор Зөвлөлтийн гэж тооцогдох соёл болон Зөвлөлтийн эрин үеэс хойш шинээр бий болж буй соёл хоорондын залгамж чанар тасарсан тухай нотолгоо баримтыг үгүйсгэхгүй боловч ... Зөвлөлт тогтолцооны үеийн түгээмэл хэллэг *“пережитки прошлого”* буюу хүмүүсийн ухамсар сэтгэхүй, амьдрал үйлд өнгөрснөөс үлдсэн ул мөр нь Зөвлөлтөөс хойшхи эрин үеийн үндсээрээ өөрчлөгдөн хувьссан нөхцөл байдалд шинэ хэлбэрийг олж хэрэглээнд нэвтэрч болзошгүй юм гэсэн сэжиг таамгийг дэвшүүлж байна. Аль ч утгаар, 1991 оныг хүртэл хугацаанд ЗСБНХОУ-ын эрхийг баригч захиргааны үзэл номлолд орсон өөрчлөлт, залгамж холбооны асуудлыг судлах ажлыг бид урьдаар тухайн үзэл номлол нь чухам ямар утгатай байсан, Зөвлөлт дэглэм нурахаас өмнө тэдгээр нь хэрхэн хувьсан өөрчлөгдсөн болохыг танин мэдэхгүйгээр эхлүүлэн явуулж чадахгүй”³⁰ гэсэн дүгнэлт юм. Энэ бол Монгол, Оросын ард түмний оюун санааны амьдралд тогтоосон үзэл санаа, дархлааг дүгнэн ойлгох, хоёр орны найрамдалт албан харилцааны зуун жилийн түүхийн сургамж, залгамжлах ирээдүйн чиг хандлага, боломжит хувирал төлвийг танин мэдэх гол аргачлал, харах өнцөг болж чадахуйц үндэслэл бөгөөд бид чухам юуг анзаарч анхаарвал зохистой болохыг бүрэн илэрхийлж чадах оновчтой чухал санаа мөн.

3. Дархлааны тун болгож түгээсэн үзэл санаа, тусгай мэдлэг

“Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. [...] Оюуны үнэт зүйл бол [...] үндэсний баялаг мөн.” Монгол Улсын Үндсэн хууль³¹

³⁰ Evans, Alfred B., "Soviet Marxism-Leninism : the decline of an ideology", London, 1993, p.4-5.

³¹ Монгол Улсын Үндсэн хууль (1992) -“Монгол Улсын бүрэн эрхт байдал” хэмээх Нэгдүгээр бүлгийн долдугаар зүйлээс.

Оюун санааны дархлаа болгоход ашигласан гол үзэл баримтлалыг тэр үеийнх нь агуулга, хэлбэр, “орц найруулга, тун, томьёо”-г алдагдуулахгүйгээр авч үзэх нь “тухайн үзэл номлол нь чухам ямар утгатай байсан”³² болохыг танин мэдэхэд илүү тохиромжтой.

Марксизм, Ленинизм, шинжлэх ухааны материализм, бурхангүй үзэл, социализм, коммунизмын тухай мэдлэг, боловсрол

Марксизм дэлгэрэхээс өмнө Монголд Энэтхэгээс Буддизм 2000 гаруй жилийн тэртээгээс их бага хэмжээгээр хүчтэй дэлгэрч түүний олон төрлийн мэдлэг ухааныг хөгжүүлж сүм хийдийг байгуулж олон тооны лам хувраг төрөн гарч, хутагт хувилгаан, мэргэдүүд ном бүтээлээ монгол болон төвд хэлээр туурвин Монголын нийгмийн оюун санаанд нэвт шингэсэн дорнын соёл, сэтгэлгээг хөгжүүлж чадсан байсан авч энэ байдал удаан үргэлжилэлгүй, XX зууны 20-оод онд Зөвлөлтөөс марксист-ленинист үзэл хандлага Монголын нийгэмд байр суурь эзлэн нэвтэрч улмаар коммунизм, социализмын замналаар бүхэл бүтэн зууны турш амьдарсан түүхтэй.

В. И. Лениний Орос оронд нөлөөлсөн ялангуяа ард түмнийх нь оюун санааны дархлаанд батжин тогтсон харь соёл, европын олон соёлын нөлөөг бид харгалзан үзэхгүйгээр дан ганц хоёр хөршид болсон хувьсгал хийгээд оюун санааны дархлаажуулалтын уг шалтгааныг бүрэн дүүрэн нээн харж чадахгүй юм.

Тухайлбал, Лениний үзэл хандлага болсон олон зохиол бүтээл төрөхөд Германы болон барууны олон орны капиталист болон капиталист бус сэтгэгчид, нийгэм улс төрийн томоохон зүтгэлтнүүдийн бүтээл туурвил, бусад онцгой хүчин зүйлс нөлөөлсөн байх бөгөөд Оросын хөрсөнд тэдгээр хүчин зүйлийг тусгах ажлыг хийсэн нь түүний үзэл сургааль, номлолоос нь харагдана. “Платоноос Фейербах хүртэл, байгалийн шинжлэл, утга зохиол судлал, хэл шинжлэл, оросын болон дэлхийн уран зургийн түүх, хөгжим, театр зэргийн тухай ном, материалууд байв. В.И.Лениний номын санд арван есөн хэл дээр гарсан ном байсан”³³ ба тэрбээр англи, герман, франц, итали, польш, швед, чех, эртний грек, латин зэрэг 9 хэл мэддэг байжээ.

Зөвлөлт төрийн үндэсний бодлогын зарчим Дорно дахин дахь колон, хагас колонийн байдалд байсан улс орнуудын зүгээс их талархал сайшаал хүлээсэн гэгддэг бөгөөд Ленинтэй уулзахаар Энэтхэг, Афганистан, Иран, Монгол, Индонези, Японоос хүмүүс ирж байв,-

1920 оны зун Д.Сүхбаатар, Д.Лосол, Х.Чойбалсан тэргүүтэй Монголын хувьсгалчдын төлөөлөгчид Эрхүү хотод хүрэлцэн ирж³⁴ төлөөлөгчдийн нэг хэсэг нь Москвад ирж удирдагч В.И.Ленинтэй уулзсан гэгддэг. Өмнө өгүүлсэнчлэн, Монголд Оросын нөлөөтэй ардын хувьсгал ялсны дараа Д.Сүхбаатар тэргүүтэй Монголын засгийн газрын төлөөлөгчид 1921 оны 10 дугаар сард Москвад уулзалт, хэлэлцээ хийсний үр дүнд хоёр талын найрамдал, эрх тэгш байдлыг гэрээгээр

³² Evans, Alfred B., “Soviet Marxism-Leninism : the decline of an ideology”, London, 1993, p.5.

³³ Л.Кунецкая, К.Маштакова. Ленин аугаа их, эгэл жирийн хүн. М.,1982. Орч.А.Бямбаноров. 50-р тал.

³⁴ Н.Хишигт. Монголын хувьсгал 1921. УБ.,2011. 172-р тал.

баталгаажуулсан. "Владимир Ильич Монгол улс капитализмыг алгасан социализмд шилжиж болох бөгөөд шилжих ч ёстой гэсэн үзэл санааг дэлгэрэнгүй өрнүүлж Монголын ард түмний соёл, гэгээрлийн түвшинг дээшлүүлэхэд онцгой анхаарал тавивал зохино гэж зөвлөж байлаа"³⁵. Улмаар Д.Сүхбаатар улс төрийн туршлага эзэмшин буцаж ардын хувьсгалын үзэл санааг туйлд нь хүргэх ажлыг эхлүүлсэн түүхтэй.

БНМАУ-ын анхдугаар их хурал 1924 оны 11 сарын 8-ны өглөө 11 цагт МАХН-ын Төв хорооны хурлын танхимд эхэлж байжээ. Их хурал тус орны тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, капиталист бус хөгжлийг хангах үндсэн нөхцөл нь ЗХУ-тай гүн зузаан найрамдалтай байх явдал мөн хэмээн үзэж, 1921 онд Монгол-Зөвлөлтийн хооронд байгуулсан гэрээг сайшаан баталж, улмаар анхдугаар үндсэн хуулийг 1924 оны 11 сарын 26-ны өдөр Ерөнхий сайд Б.Цэрэндоржоор ахлуулсан тусгай комисс уг төслийг богино хугацаанд "МАН-ын Төв Хороо, Ардын Засгийн Газар үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг түргэвчлэх зорилгоор ЗХУ-аас мэргэжилтэн урихаар шийдвэрлэжээ. Тэр ёсоор ЗХУ-аас хууль цаазны ухааны мэргэжилтэн П.В.Всесвятскийг 1924 оны V сард ирүүлсэн нь үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг хурдасгаж, түүнд зөвлөлтийн үндсэн хуулийн хувьсгалт үзэл санаа, ардчилсан зарчмыг Монголын нөхцөл байдалд тохируулан бүтээлчээр тусган хэрэглэхэд түлхэц болсон байна. Үндсэн хуулийн төслийг боловсруулахад Коминтерний төлөөлөгч Э.Ринчино, Т.Рыскулов нар чухал үүрэг гүйцэтгэсэн аж."³⁶ Эдгээр үйл ажиллагаа тухайн үедээ маш их нөлөөг үзүүлж, зааварлан зөвлөгч үүргийг гүйцэтгэж ирсэн бөгөөд оюун санааны бүхий л хүрээг хамарч байв.

Тус их хурлаар олон асуудлыг хэлэлцэж тогтсоны нэгэнд улсын нийслэлийн нэрийг тогтох шинээр өөрчлөх асуудал байлаа. Судлаачид улсын нийслэлийн нэрийг түүхийг олон янз тайлбарлаж тайлж "Хурал дээр харин Жадамба "Баатар" хот гэсэн нэрээ түлхэж дэмжлэг аваад байтал"³⁷ Коминтерний Монгол дахь төлөөлөгч нарын нэг болох Т. Рыскуловын "Улаан" гэсэн тодотголыг нэмж оруулсныг түүхчид дурддаг. Энэ бол Орос дахь интернационалч эрх баригчид Монголын нийгэм, ард түмний оюун санааны амьдралд үзүүлж байсан нөлөөлөл, төрөл бүрийн тогтоож байсан "дархлаажуулалт" давамгайл байсныг илтгэдэг.

"1920 онд Коминтерний хоёрдугаар Их хуралд энэтхэгийн коммунист Рой үндэсний асуудлын талаар хавсралт сонсгол хийхээр сэдэв боловсруулаад Ленинд үзүүлж байжээ. Ленин түүний сэдвийг үзээд Дорно дахины орнуудад шууд "коммунист нам" байгуулж болох мэтээр бичснийг дарж "хувьсгалт нам" байгуулж болно гэж засварласан байдаг. Энэ үүднээсээ Ленин Монголын хувьсгалчдад

³⁵ Л.Кунецкая, К.Маштакова. Ленин аугаа их, эгэл жирийн хүн. М.,1982. Орч.А.Бямбаноров. 252-р тал.

³⁶ М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ.,1974 137-р тал.

³⁷ Д.Өлзийбаатар. 90 гаруй жилийн түүхтэй "Улаанбаатар" нэрний тухай.
<https://www.uqluu.mn/336325.html>

малчны нам байгуулахыг зөвлөж, капиталист бус замаар хөгжих асуудлыг тавьж байв”³⁸.

Марксист философийн суурь үндэс нь материализм бөгөөд нийгмийн хөгжлийг “матери”-ийн хөдөлгөөний дээд хэлбэр гэж тайлбарладагаараа бусад Барууны гэгдэх орны философи баримтлалаас ялгаатай. Улмаар төр, шашин тус тусдаа хөгжих нь зөв хэмээн 1924 онд хэмжээт цаазат хаант ёсыг халж Бүгд найрамдах засгийг тунхагласан Коминтерний зааварчилгаан дор хийгдсэн анхдугаар үндсэн хуулиар шашныг төрөөс тусгаарлах эхлэлийг тавьжээ. Эл үзэл хандлагыг хуульчилснаар Монголын ард түмний оюун санаанд гүн бат шингэсэн соёлын дархлаа аажимдаа Орос, Зөвлөлтөөс орж ирсэн шинэ үзэл хандлага, сургаалаар солигдсон юм.

1924 оны Үндсэн хуулиар бататгаж хутагт хувилгаад, орон хийдэд үргэлж суух санваартан лам нарын сонгуулийн эрхийг хасчээ. Үндсэн хуулиар: “Тус улсын харьяат аливаа хүний шүтэх итгэх явдалд бүрнээ эрх чөлөө олгохын тулд шашны хэргийг улс төрийн хэргээс тусгаар байлгаж, шашин шүтлэгийн явдлыг өөр өөрийн дур сүсгээр болговол зохино” гэж тунхагласан бөгөөд Үндсэн хуулийн энэ заалтыг намын хөтөлбөрт шашны асуудлаар намаас баримтлах үндсэн зүйл болгосон³⁹. “Объектив нөхцөл байдлын улмаас нам шашныг үзэн ядаж дайсгах утгаар шашингүйн суртлыг баримтлан явуулж болохгүй байсан ба энэ асуудлын талаар улс орны өвөрмөц онцлогийг харгалзан МАХН-ын баримталсан бодлогыг Коминтерн дэмжиж байсан нь 1926 оны 1-р сард Коминтерний Гүйцэтгэх Хорооноос Монголын асуудлаар гаргасан тогтоодоо: “Шашин шүтлэгийн хэрэгт шууд эсэргүүцэх явдлыг Намын Төв Хорооноос мөн нарийлан үзэж болгоомжлон явуулж буй нь их л зүйтэйн гадна энэ хир Монгол Ардын Хувьсгалт Намаас бурхангүй хэмээх суртлыг дэлгэрүүлэх цаг хараахан болоогүй”⁴⁰ гэж зааснаас илэрхий. Лам нарт хандах анхны оролдлогыг 1925 оны 04 дүгээр сард Намын Төв Хорооноос гаргасан “Монгол Ардын Хувьсгалт Намын шашин шүтлэгийн тухай гол бодлого ба товч тогтоол” гэдэг баримт бичигт байна. Тэрхүү баримт бичигт Монголын ард түмний үндэсний болон нийгмийн дэвшлийн үйлст буддын шашны гүйцэтгэсэн харгис үүргийг илчлэн, лам нарыг ангийн байдлаар нь дээд, дунд, доод хэмээн гурав хувааж харгис дээд лам нарын эсрэг тэмцэлд доод, дунд лам нарыг дэмжиж зорилт дэвшүүлжээ”⁴¹. Мөн нэгэн жишээг Д.Дашжамц номондоо иш татсан нь “1925 оны эхээр Коминтернд ажиллаж байсан Японы коммунист зүтгэлтэн Сен Катаямаа Монголд ирээд Улаанбаатар хотын нам, эвлэлийн гишүүдтэй уулзахдаа: “ламаизмын тухай асуудлыг эс хөндөх арга алга. Монголд энэ талаар бүхэл бүтэн хувьсгал хийвэл зохих орон гэж бодогдох юм. Би шашны асуудлыг хэрхэн шийдсэн талаар хоёр жишээ хэлэлтэй. Нэгд, 1808 онд Японд ийм хувьсгал хийж шашны асуудлыг шийдэж хүрээ хийдийн сүм дугана сэлтийг нь

³⁸ Д.Дашжамц. Марксизм-Ленинизм Монголд дэлэгэрэн хэрэгжсэн нь (1917-1940 он) УБ.,1973. 127-128-р тал.

³⁹ БНМАУ-ын их, бага хурлын тогтоол. 31 дэх тал.

⁴⁰ НТА., Ф-1.Т-23, ХН-19.

⁴¹ Б. Лхамсүрэн, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь”, УБ., 1975, 107-108-р тал.

улсын санд шилжүүлсэн. Буддын сүм дуганд нь сургууль байгуулсан, би түүнд боловсрол эхэлж олсон. Хоёр дахь нь Зөвлөлт Оросын жишээ билээ. Тэнд лам нар сүм хийдийн асуудлыг зөв аргаар шийдсэн.... Ламаизм бол Монгол, Буриадын ард түмний цэцэглэл, хөгжилд өгүүлшгүй саад уруулж байна”⁴² гэж хэлж байжээ.



Юрий Алексеевич
Гагарин: “Бурхан
алга!”, 1961.

Юрий Алексеевич Гагарин 1961 оны 04 дүгээр сарын 12-нд хүн төрөлхтний дундаас анх удаа сансарт нисч, сансар огторгуйн уудамтай танилцаад, Бурхан алга!” хэмээн илтгэж буйг харуулсан ЗХУ-ын зурагт хуудас нь шашин, сүм хийд ард түмний оюун санааны амьдралд үзүүлж байсан нөлөөллийг багасгах чиглэлд эрх баригчид уян хатан, дэс дараатай суртал явуулж байсныг харуулдаг.

Анх 1953 онд эрдэмтэн Х.Пэрлээ “Монголд марксизм дэлгэрсэн нь” өгүүллээ Шинжлэх ухаан сэтгүүл (УБ.,1953 №3)-д бичсэнээр манайд уг асуудлыг тусгайлан хөндсөн анхны шинжлэх ухааны судалгааны өгүүлэл болж гарсан гэгддэг бөгөөд түүнээс хойш 1960 оныг хүртэл дорвитой бүтээл гараагүй гэж үздэг. Харин БНМАУ-ын түүх, МАХН-ын түүхий талаар гарсан зохиол бүтээлд марксизм-ленинизмын үзэл санаа дэлгэрэн хэрэгжсэн асуудлаар түүх, нийгмийг авч үзэх болж 1960-аад оны хоёрдугаар хагаст Б.Ширэндэв, Б.Балдроо, Б.Сумъяа, Л.Санжаа, Д.Даш, Г.Дэлэг, С.Норовсамбуу нарын эрдэмтэд өөрсдийн бүтээлүүдэд Монголд марксизм-ленинизмын үзэл санаа дэлгэрсэн асуудлыг олон талаас нь хөндөж тайлбарлан⁴³ сурталчилж хэмээн Д.Дашжамц өөрийн бүтээлдээ үзсэн байна.

Тухайлбал, академич, философич С.Норовсамбуу нь 1965 онд “Капитализмын өмнөх харилцаа ноёрхож байсан орнуудад ялсан ардчилсан ба социалист хувьсгалын харьцаа, онцлогууд (БНМАУ-ын жишээгээр)” гэдэг бүтээлдээ “Монголын ард түмэн түүний манлайлагч МАХН нь ЗХУКН-ын XX, XXI, XXII их хурлуудын түүхэн шийдвэрүүд, ялангуяа орчин үеийн коммунист тунхаг болсон ЗХУКН-ын шинэ программыг маш сэтгэл хангамжтай хүлээж авсан юм. Дэлхийн коммунист хөдөлгөөний жанжин шугам бол 1960 оны зөвлөлгөөний тодорхойлсноор энх тайван, ардчилал, үндэсний тусгаар тогтнол ба социализмын төлөө тэмцлийн шугам, социализм, коммунизмын ялалтын төгс дүүрэн хангах шугам мөн.”⁴⁴ гэжээ.

Мөн түүний 1973 онд хамтран зохиогчоор оролцсон “Диалектик материализм. Дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг”. “Түүхийн материализм. Дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг” гэсэн бүтээлүүдэд шинжлэх ухааны материализм, коммунизмын онолын боловсрол мэдлэгийг түгээж өгсөн байна. Олон зуун жилээр харь орны хараат байж дэлхийн

⁴² Мөн тэнд. 170-р тал.

⁴³ Д.Дашжамц. Марксизм-Ленинизм Монголд дэлгэрэн хэрэгжсэн нь (1917-1940 он) УБ.,1973 4-р тал.

⁴⁴ Монголын философичдын өв. УБ.,2020 289-р тал.

хөгжлөөс хоцрогдож явсан Монгол орон XX зуунд тусгаар тогтнож, зөвлөлтийн марксизмын нөлөөгөөр нийгэм улс төр, оюун санааны хувьд томоохон дэвшилд хүрсэн нь маргаангүй гэдгийг үндсэндээ хүлээн зөвшөөрдөг билээ.

“Орос бол К. Марксын зөгнөсөн улс төрийн хувьсгалыг анхлан эхлүүлсэн орон бөгөөд Зөвлөлтийн марксистууд, радикал сэхээтнүүд Маркс, Энгельсийн зохиол бүтээлийг үндэслэн “диалектик материализм” хэмээх түүхэн хувьсгал, нийгмийн хөгжлийн түгээмэл хуулиуд хэмээх онолыг бүтээжээ. Зөвлөлтийн марксист онолчид зөвлөлтийн социализм бол дэлхийн түүхэн хөгжлийн эцсийн шатандаа орсон дэвшилтэт нийгэм хэмээн номлох болсон байна.”⁴⁵

Эдүгээ материализм, коммунизмын онол, үзэл баримтлал хоёр орны нийгмийн зонхилох үзэл суртал байхаа больсон боловч орчин цагийн капиталист нийгмийн мөн чанар, уг сурвалжийг шинжлэх ухаанчаар шүүн шинжилсэн сэтгэгч Карл Маркс, түүний залгамжлагчдын суурь судалгаа, бүтээлүүд улс төр, эдийн засгийн байгууллын асуудлаар ач холбогдлоо алдалгүй, дахин эргэлтэд орсоор байна.

Интернационализм ба интернационалч шинжтэй национализм:

энх тайвнаар зэрэгцэн оршин орших болон эх оронч-үндэсэрхэх үзлийн өвөрмөц тэнцвэрийн томъёо

В. И. Ленин “Хүн төрөлхтний аж ахуй, улс төр, санаа сэтгэлийн бүх амьдрал нь капитализмын үед улам бүр интернационалчлагдаж байна. Харин социализм амьдралыг бүхэлд нь интернационалчилна”⁴⁶ гээд, “жинхэнэ интернационализм ганцхан, гав ганцхан байдаг бөгөөд энэ нь өөрийн орны дотор хувьсгалт хөдөлгөөн, хувьсгалт тэмцлийг хөгжүүлэхийн тулд мятаршгүй ажиллаж, аливаа бүх орны тийм тэмцэл, тийм шугамыг суртал нэвтрүүлдэг, талархал, эд материалаар дэмжих явдал мөн”⁴⁷ гэж бичжээ.



В. Соловёв, “ЭНХ ТАЙВАН ДАЙНЫГ ЯЛАН ДИЙЛНЭ!” зураг. 1961.

Б. Лхамсүрэн “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь” (1975) бүтээлдээ үндэсэрхэх үзлийн асуудлыг интернационалист хандлагатай хэрхэн хоршуулан нэгтгэж байсныг тусгайлан авч үзчээ. Тухайлбал, “улс төрийн тусгаар тогтнолын төлөө тэмцлийн үед нэгтгэгч хүчин зүйл болж байсан үзэл, лоозонгууд ардын хувьсгал ялсны дараа бий болсон нөхцөлд тэр бүр тохирохоо болив.

Нөхцөл байдал өөрчлөгдөж, ялангуяа улс орны цаашдын хөгжлийн замыг нэгэнт сонгон авсантай холбогдон улс үндэстний асуудлыг шинээр сэтгэж шинэ үзэл, лоозон гаргах явдал шаардагдав. Юуны өмнө хувьсгалаар мэндэлсэн ардын

⁴⁵ Монголын философичдын өв. УБ., 2020 138-р тал.

⁴⁶ В. И. Ленин, Зохиолууд, 19-р боть, 248-249-р тал.

⁴⁷ В. И. Ленин, Зохиолууд, 24-р боть, 59-р тал.

төрийн бүрэн эрхийг бататган тогтоох үзэл санаа дэвшигдэн тавигдсан бөгөөд энэ нь намын үндэсний бодлогын гол утга агуулгыг бүрдүүлсэн юм. Монгол Ардын Хувьсгалт Намын хөтөлбөрт “Ардын намаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүрэн эрхийг эдэлж, тусгаар тогтнох замаар буцалтгүйгээр аливаа хэргийг явуулж буй бөгөөд мөнхүү явдлыг бат бэх болгохоос гадна хувьсгалын хүчнээр олсон зүйлүүдийг гадаад, дотоодын дайсан этгээд халдаар ирэх бол өмгөөлөн хамгаална”⁴⁸ гэж цохон тэмдэглэжээ. Улс орны гадаад байдал нарийн түвэгтэй, түүний тусгаар тогтнолыг капиталист гүрнүүдийн зүгээс үл тоомсорлож, ялангуяа хятадын милитаристууд цэргийн хүчээр түрэмгийлэх буюу дотоодод хуйвалдаан гаргах замаар Монголыг Хятадын муж болгох бодол санааг үл орхин дайсагнасаар байсан учир хөтөлбөрийн энэхүү заалт онцгой чухал ач холбогдолтой байлаа.

Үндэсний асуудлын талаархи намын бодлогын интернационалч шинж хүчтэй болсны нэг илрэл нь намын IV их хурлын шийдвэрт: “Монгол үндэстнийг өөрсдийн дур саналыг үл харгалзан нэгтгэнэ гэгч хүчин нь алс дорнод зүгийн улсууд ба ялангуяа Хятадын эрх чөлөөгөө олох үндэсний хувьсгалын зэрэг хэргүүдийг зохилдуулан нэгтгэх явдалд хортой болохыг илэрхийлнэ”⁴⁹ гэж тэмдэглэсэн явдал болно”⁵⁰.

“1934 онд хуралдсан МАХН-ын IX их хурал хувьсгалын агуулгатай, үндэсний хэлбэртэй соёлыг хөгжүүлэх шийдвэр гаргасан нь чухал ач холбогдолтой байв. Их хуралд оруулсан Намын Төв Хорооны илтгэлд соёлын байгуулалтын чухал зорилт бол улс төрийн нийт шаардлагад зохицуулан эх орон, нэгдмэл төр улс, жинхэнэ ардын эрхт ёсыг гүнээ ухамсарлах, хүмүүсийн ухамсар, ахуй дахь феодализмын нөлөө, үлдэгдлийн эсрэг тэмцэх үзлээр ард олныг хүмүүжүүлэхэд оршино гэж дурдсан байна. Үүний хамт, үндэсний явцуу үзэл гаргах, монгол үндэстнийг бусад үндэстэнд эсэргүүцүүлэн, бусад үндэстний хүмүүс болон тэдний соёлыг дайсагнан доромжлох үндэсний бүрхүүлдээ орж бусдаас тасрахын эсрэг тууштай тэмцэхийг чухалчлан заажээ”⁵¹. Их хурлын тогтоолд: “Үндэсний соёл, үндэсний ухамсрыг хөгжүүлэхдээ БНМАУ-ын ард түмнийг дарлагдсан ба жинхэнэ хувьсгалт орнуудын ард түмэнтэй улс төр, соёлын талаар ойртуулж, эзэрхэг түрэмгий ба дотоодын харгисуудыг эсэргүүцсэн нийтийн тэмцэлд эв санал нэгтэй байх үзлээр хүмүүжүүлэхэд чиглүүлбэл зохино”⁵² гэжээ.

“Монгол-Зөвлөлтийн харилцаа нь их, бага ард түмний хоорондахь жинхэнэ интернационалч холбооны биет жишээ болон тогтжээ. Их, бага үндэстний хоорондахь сайн дурын холбоо, эв нэгдлийн мөн чанарыг тодорхойлж”⁵³, В. И.

⁴⁸ МАХН-ын их, бага хурал, Төв хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэрүүд: I хэсэг, УБ., 1956, 109-р тал.

⁴⁹ МАХН-ын их, бага хурал, Төв хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэрүүд: I хэсэг, УБ., 1956, 109-р тал.

⁵⁰ Б. Лхамсүрэн, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь”, УБ., 1975, 110-р тал.

⁵¹ Б. Лхамсүрэн, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь”, УБ., 1975, 130-р тал.

⁵² “МАХН-ын есдүгээр их хурал” (орос хэл дээр), УБ., 1934, 233-р тал.

⁵³ Б. Лхамсүрэн, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь”, УБ., 1975, 131-р тал.

Ленин хэлэхдээ, ийм харилцаа тогтоохын тулд их үндэстний пролетарийн интернационализм нь бага үндэстний жинхэнэ тэгш эрхийг зөвшөөрөн хамгаалж, сайн дураар ойртон нийлэхэд нь туслахад орших бөгөөд бага үндэстний хувьсгалт хүчний интернационализм нь үндэсний явцуу түгжигдмэл, тусгаарлагдмал үзлийн эсрэг тэмцэж сайн дураар ойртон нийлэхийг ухамсартай эрмэлзэхэд оршино⁵⁴ гэжээ.

Интернационалист хөгжил болон интернационалч националист чиг баримжаа, буюу өөрөөр хэлбэл, энх тайвнаар зэрэгцэн орших үзэл болон эх оронч-үндэсэрхэх үзэл хоорондын өвөрмөц тэнцвэрийг томьёолж, өндөр түвшний шийдэл гаргасан нь эргэн харахад тод байна. Энэхүү томьёолол аливаа улс орны аюулгүй байдлыг хангахад хойшид ч дархлаажуулалтын хувилбар сонголт хэвээр хамааралтай байх болов уу.

Фашист, нацист, империалист, милитарист, колонист, капиталист эрх баригч бүлгийн бодлогыг сөрөн зогсох үзэл хандлага, тусгай мэдлэг

Фашист, нацист, империалист, милитарист, колонист, неоколонист, капиталист, монополист, төрөл бүрийн бусад үзэл суртал, далд бодлогыг баримтлагч, Өрнө, Дорнын улс орнуудын эрх баригч бүлэглэлийг эсэргүүцэн тэмцэх үзэл хандлага, судалгаа мэдээлэл, тусгай мэдлэг, арга ажиллагаа нь хоёр орны ард түмэнд өнгөрөгч зуун жилийн хугацаанд тогтоосон оюун санааны дархлаажуулалтын хамгийн чухал тун юм.

Энэхүү тунг түгээмэл боловсрол, мэдээллийн хэрэгсэл, хэвлэмэл болон бусад бүтээл, дээд болон тусгай боловсрол, улс төрийн нам, шинжлэх ухааны байгууллага, төрийн чиг үүргийн блоон тусгай албаар дамжуулан зохих арга хэлбэрээр дамжуулан хүргэж байсан.

Хамгийн сүүлд энэхүү дархлааг тогтоох аян 1980-аад оны дунд, сүүл үед идэвхижээд, түүнээс хойш илүү хязгаарлагдмал, өөр хэлбэрт шилжин хумигдсан байна. Биологийн дархлаажуулалтын ойлголтоор зүйрлүүлэн илэрхийлбэл, уг дархлаажуулалтын үр нөлөө арилж эхэлсэн бөгөөд одоо цагийн нөхцөл байдал, аюул эрсдэл, хувирал өөрчлөлтөд тохируулан шинэчилсэн, эсхүл сайжруулан хөгжүүлсэн “тарилга тунг тодорхой үе шаттайгаар давтан хийх” хэрэгцээ шаардлага үүссэн гэж хэлж болно.

ДҮГНЭЛТ, ТААМАГ

“Зөвлөлт Холбоот Улсын эрин үеийг нэхэн санадаггүй иргэд зүрх сэтгэлгүйтэй адил, харин Зөвлөлт Холбоот Улсын эрин үеийг нэхэн авчрахыг хүсдэг иргэд оюун ухаангүйтэй адил [...] Дэлхий дахин дахь нөхцөл байдал хувьсан өөрчлөгддөг”. В. В. Путин

1. Дэлхий дахин хүн хоорондын оюун санааны ертөнц болон эргэлт буцалтгүй хувирсан тул оюун санааны дархлаажуулалт урьд цаг үеэс

⁵⁴ В. И. Ленин, Зохиолууд, 22-р боть, 369-р тал.

ялгаагүй хамааралтай, улс орны оюулгүй байдалд шууд нөлөөтэй хэвээр байна.

2. Хоёр орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдлыг хамгаалан бэхжүүлэхэд шаардагдах тусгай мэдлэгээр өнгөрөгч зуун жилд Монгол, Оросын ард түмнийг дархлаажуулсан.
3. Дархлаажуулалтад, бичиг үсэг мэдүүлэх, боловсрол, шинжлэх ухааны мэдлэг, соёл, урлагийн хөгжлөөр хангахаас гадна, Марксизм, Ленинизм, шинжлэх ухааны коммунизм, социализмын үзэл санаа, улс төрийн эдийн засаг, интернационализмын үзэл, түүнчлэн фашизм, нацизм, империализм, милитаризм, колонизм, неоколонизм, капитализм, бусад үзэл бодлого бүхий Өрнө, Дорнын улс орнууд дахь эрх баригч бүлэглэлийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцэх үзэл хандлага, цогц тусгай мэдлэг чухал үүрэг гүйцэтгэсэн.
4. Үзэл санаа, бодлого, номлол, баримтлалыг дархлаажуулах тун болгон ашигласантай холбоотой эерэг, сөрөг үр дагаврыг үнэлэх нь амаргүй ажил бөгөөд юутай ч хоёр орны ард түмний оюун санааны “талх” үйлдвэрлэл тасалдаагүйн үр дүнд хөгжлийн ямар ч чиг баримжааг баримтлах, олон ургальч үзлийг хүлээн авах таатай хөрс суурь өнгөрөгч зуунд бий болсон.
5. Холбогдох үзэл санааны үндэс, түүнийг нэвтрүүлэгч жинхэнэ хөдөлгөгч хүч, зохион байгуулагч болсон эзэд, эрх баригч, интернационалч бүлэглэлийн мөн чанар одоог хүртэл бүрэн танигдаж ил болоогүй, түүхийн нягтлан шалгалт шаардсан, гүн гүнзгий судалгаа шаардсан, бие даасан эргэлзээтэй сэдэв хэвээр байна.
6. Ард түмний ахуй-сэтгэхүйд “өнгөрснөөс үлдсэн ул мөр” болж үйлчилсээр буй, түүнчлэн шинжлэх ухааны үндэслэлтэй суурь судалгааны нөлөө холбогдол арилаагүй зэрэг шалтгаанаар, холбогдох үзэл хандлагууд, тэдгээрийн авч үздэг аюул заналууд цаг үеийн нөхцөл байдалд нийцэн хувьсан өөрчлөгдөж, шинэ хэлбэр төрхөөр гарч ирэх үзэгдэл гарцаагүй байна. Энэ нь НҮБ-ын хэмжээнд олон талт шийдвэр гаргах үзэл зэргээр сүүл үед илэрч байж болзошгүй. Урьд цагийн үзэл хандлагуудын орчин цаг дахь хамаарлыг илрүүлэхэд анхаарлыг чиглүүлсний хувьд уг өгүүлэл ач холбогдолтой.
7. Түүхийн урт удаан найрсаг харилцаатай, хөрш залгаа, хилийн зурвас харилцан халхлагдаж байдаг Монгол, Орос хоёр орны ард түмэн Еврази, бүс нутаг болон дэлхий дахинд оюун санааны манлайлал, удирдлага, дархлаажуулалт хэрэгжүүлэх өндөр нөөц, давуу боломжтой хэвээр байна.

Эх сурвалжийн жагсаалт

А/ Монгол хэл дээр:

1. БНМАУ-ын их, бага хурлын тогтоол.
2. “БНМАУ”-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл”, I боть, УБ., 1964.,
3. Д.Дашжамц. Марксизм-Ленинизм Монголд дэлгэрэн хэрэгжсэн нь (1917-1940 он)УБ.,1973
4. Л.Кунецкая, К.Маштакова. Ленин аугаа их, эгэл жирийн хүн. М.,1982. Орч.А.Бямбаноров..

5. Б.Лхамсүрэн, “МАХН-ын үйл ажиллагаанд интернационализмын зарчим хэрэгжсэн нь”, УБ., 1975,.
6. В.И.Ленин, Зохиолууд, 19-р боть
7. В.И.Ленин, Зохиолууд, 22-р боть
8. МАХН-ын их, бага хурал, Төв хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэрүүд: I хэсэг, УБ., 1956,.
9. “МАХН-ын есдүгээр их хурал” (орос хэл дээр), УБ., 1934,
10. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. УБ.,
11. Монгол Улсын Үндсэн хууль (1992) - “Монгол Улсын бүрэн эрхт байдал” хэмээх Нэгдүгээр бүлгийн долдугаар зүйлээс
12. “Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1978)”, УБ., 1981,
13. Монголын философичдын өв. УБ.,2020
14. НТА.,Ф-1,Т-23, ХН-19
15. Д.Өлзийбаатар. 90 гаруй жилийн түүхтэй “Улаанбаатар” нэрний тухай. <https://www.uqluu.rnn/336325.html>
16. Салих Закиров. Алтан Ордны улсаас Египеттэй барьж байсан дипломат харилцаа (ХШ-Х1Vзуунд). УБ.,2004.
17. М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ.,1974
18. Үнэн" сонин, 1971 - 03 - 01, №52
19. Н.Хишигт. Монголын хувьсгал 1921. УБ.,2011.
20. Г.Цэрэндорж, “БНМАУ-д бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгасан нь”, УБ., 1976,

Б/ Гадаад хэл дээр:

1. Brandenberger, David, “Propaganda state in crisis : Soviet ideology, indoctrination, and terror under Stalin, 1927-1941”, Yale University Press, 2011
2. V. Durdenevskii, “The People’s Republics of Central Asia-Mongolia and Tuva”, in S.S., 1929, No. 3 (9), 1929,
3. Claudia Dittmar, “GDR Television in Competition with West German Programming”, *Historical Journal of Film, Radio and Television* Vol. 24, No. 3, 2004,
4. Evans, Alfred B., “Soviet Marxism-Leninism : the decline of an ideology”, London, 1993,
5. Martin Buber, “Between Man and Man”, Routledge Classics, 2002,
6. Gerard M. Fritzers, “Outer Mongolia and its International Position”, London, 1951,
7. Peter Busch, “West German Psychological Warfare against East German Propaganda in the 1960s
8. “Webster’s New World Medical Dictionary”, Third Edition, New Jersey, 2008
9. Schlomann, “Der psychologische Krieg der DDR
10. Л.Н.Гончаренко, “Отечественная история”, Русь и Орда: Проблемы взаимодействия.
11. И.Я.Златкин, “Очерки новой и новейшей истории Монголии”, 1957.
12. Б. Ширэндэв, “Монголия на рубеже XIX-XX веков”, УБ., 1963.